

ТАНИЛЦУУЛГА

“Эрхийг хязгаарлах, эрх бүхий албан тушаалтан, шүүх болон эрх бүхий байгууллага хооронд мэдээлэл солилцох журам”-ын төслийн талаар

Зөрчлийн тухай хуулийн тухай хуулийн 3.4 дүгээр зүйлийн 8-д “Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт зөрчсөнтэй холбогдуулан эрх бүхий этгээдээс оногдуулсан торгох шийтгэлийг хуульд заасан хугацаанд биелүүлээгүй бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх авах, сунгах, өөрчлөх, нөхөн авах, тээврийн хэрэгслийн эзэмшлийн шилжилт хөдөлгөөн хийх эрхийг хязгаарлана. Хүн, хуулийн этгээд эрх бүхий этгээдээс оногдуулсан торгох шийтгэлийг энэ хуулийн 3.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан хугацаанд биелүүлээгүй бол цагдаагийн алба хаагч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг торгох шийтгэлийг биелүүлж дуусах хүртэл хугацаанд хязгаарлана. Энэ тохиолдолд тээврийн хэрэгслийг хуульд заасан журмын дагуу тусгай талбайд хүргэх, эсхүл хууль, журамд заасан бусад аргаар хөдөлгөөнийг хязгаарлана.” гэж, мөн зүйлийн 9-д “Эрхийг хязгаарлах, эрх бүхий албан тушаалтан, шүүх болон эрх бүхий байгууллага хооронд мэдээлэл солилцох журмыг Улсын ерөнхий прокурор, хууль зүй асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.” гэж тус тус заасан.

Дээрх хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан тус хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Эрхийг хязгаарлах, эрх бүхий албан тушаалтан, шүүх болон эрх бүхий байгууллага хооронд мэдээлэл солилцох журам”-ын төслийг боловсрууллаа.

Энэхүү журам батлагдсанаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд харилцан уялдаатай ажиллаж, мэдээлэл, үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх, төрийн байгууллагууд хоорондоо цахимаар мэдээлэл солилцох, иргэн, хуулийн этгээдийн хувьд төрийн мэдээлэл, үйлчилгээг төрийн байгууллагад биечлэн хандаж авахаас гадна цаг хугацаа, орон зайнаас үл хамааран цахим хэлбэрээр авах боломж бүрдэх ач холбогдолтой.